



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО

ЗӨВЛӨМЖ

РАДИО, ТЕЛЕВИЗИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧДЭД

Сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх мэдэгдэл ирүүлэх тухай

Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн 46.9¹ дэх хэсэг, Радио, телевизээр сонгуулийн сурталчилгааг нэвтрүүлэх, хяналт тавих, радио телевизийг бүртгэх, бүртгэхээс татгалзах журмын 3.3 дах хэсэгт тус тус заасны дагуу радио, телевизийн үйлчилгээ эрхлэгчид нь сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх тохиолдолд санал авах өдрөөс 30-аас доошгүй хоногийн өмнө буюу 2024 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн дотор Харилцаа холбооны зохицуулах хороонд сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх тухай мэдэгдлийг ирүүлэх үүрэгтэй. Энэхүү мэдэгдлийг ирүүлэхдээ МУИХ-ын Сонгуулийн тухай хуулийн 46.9 дэх хэсгийн 46.9.1-46.9.3-т заасны дагуу

1. Сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх тухай мэдэгдэл
2. Сурталчилгааны нэвтрүүлэг явуулахаар төлөвлөсөн цагийн хуваарь;
3. Ээлжит сонгуулийн жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнөх жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд хийж байсан гурваас доошгүй зар сурталчилгаа нэвтрүүлэх гэрээ;
4. Сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх үнийн саналыг ирүүлэх шаардлагатай юм.

Иймд радио, телевизийн үйлчилгээ эрхлэгч та бүхэн МУИХ-ын 2024 оны ээлжит сонгуулиар сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэхээр төлөвлөж байгаа бол сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлэг нэвтрүүлэх тухай мэдэгдлээ хуульд заасан хугацаанд, баримт бичгийн бүрдлээ ханган Харилцаа холбооны зохицуулах хороонд 2024 оны 05 сарын 28-ны өдрийн 17 цаг 30 минутаас өмнө ирүүлэхэд анхаарч ажиллахыг зөвлөж байна.

Мэдэгдлийн маягыг ирүүлээгүй эсхүл хугацаа хоцорсон, эсхүл баримт бичгийн бүрдэл хангаагүй тохиолдолд МУИХ-ын Сонгуулийн тухай хуулийн 46.10² дах хэсэгт заасны дагуу сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлэг нэвтрүүлэхийг хориглосон болохыг үүгээр мэдэгдэж байна.

¹ 46.9.Олон нийтийн радио, телевизээс бусад радио, телевиз сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлэг нэвтрүүлэх бол сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх тухай мэдэгдлийг дараах баримт бичиг, мэдээллийн хамт Харилцаа холбооны зохицуулах хороонд санал авах өдрөөс 30-аас доошгүй хоногийн өмнө хүргүүлж, бүртгүүлнэ:

² 46.10.Энэ хуулийн 46.9-д заасны дагуу бүртгүүлсэн радио, телевиз сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх эрхтэй бөгөөд бүртгүүлээгүй радио, телевизээр сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлэг нэвтрүүлэхийг хориглоно.

Цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах тохиолдолд:

Цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах түүнд хяналт тавих журмын 3.2. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1.3-т заасан бусад цахим хуудас нь сонгуулийн сурталчилгаа нийтлэх тохиолдолд сонгуулийн сурталчилгаа эхлэх өдрөөс өмнө Харилцаа холбооны зохицуулах хороонд Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан Цахим орчны үйлчилгээ эрхлэгчээс сонгуулийн сурталчилгаанд ашиглах цахим хуудасны бүртгэлийн маягтын дагуу бүртгүүлнэ.

Дараах холбоосоор орж бүртгүүлнэ үү.

<https://election.crc.gov.mn>